

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/131/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn |
| Чойбалсан хот 2023 он | Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn |
| | Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 218

танай _____ -ны № _____ -т

Г ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.НАРАНЖАРГАЛ ТАНАА

Г Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторовын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа

011020205

тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд, холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 569,987,393.10 | 689,799,618.89 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | 114,968,550.72 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 114,968,550.72 |
| 3121 | Төгрөг | - | 114,968,550.72 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 114,968,550.72 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 569,987,393.10 | 574,831,068.17 |
| 351 | Түүхий эд материал | 101,856,716.14 | 118,156,449.14 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 101,856,716.14 | 118,156,449.14 |
| 354 | Хангамжийн материал | 468,130,676.96 | 456,674,619.03 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 468,130,676.96 | 456,674,619.03 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,453,050,002.58 | 4,510,994,710.53 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,453,050,002.58 | 4,510,994,710.53 |
| 392 | Биет хөрөнгө | 4,006,626,602.58 | 4,064,597,710.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,122,596,948.44 | 4,122,596,948.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (336,745,694.72) | (431,054,312.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 81,294,609.10 | 200,523,033.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30,458,592.71) | (32,133,958.73) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 109,680,773.29 | 119,061,407.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (52,041,048.24) | (62,656,647.31) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 123,572,989.00 | 158,692,989.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (11,273,381.58) | (19,673,908.92) |
| 39217 | Ном | - | 9,242,160.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 446,423,400.00 | 446,397,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,384,500.00 | 3,384,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,336,100.00) | (3,362,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 446,375,000.00 | 446,375,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,023,037,395.68 | 5,200,794,329.42 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,023,037,395.68 | 5,200,794,329.42 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,023,037,395.68 | 5,200,794,329.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,441,984,414.04 | 1,441,984,414.04 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,441,984,414.04 | 1,441,984,414.04 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,405,232,575.95 | 1,582,989,509.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,405,232,575.95 | (3,617,804,819.73) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 5,200,794,329.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,175,820,405.69 | 2,175,820,405.69 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,023,037,395.68 | 5,200,794,329.42 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,185,422,153.02 | 7,972,075,448.68 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 236,669,949.02 | 5,200,749,948.68 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 236,669,949.02 | 5,200,749,948.68 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 236,669,949.02 | 70,435,150.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,880,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 62,554,750.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -ҮНДСЭН ХӨРӨНГӨ | - | 4,539,018,262.58 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -БАРАА МАТЕРИАЛ | 236,669,949.02 | 591,296,536.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 186,572,804.00 | 2,771,325,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 2,627,281,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,627,281,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,762,179,400.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 130,880,004.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 92,323,004.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 38,557,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 55,692,800.00 | 144,043,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,692,800.00 | 144,043,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,053,144,729.38 | 2,771,281,119.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,053,144,729.38 | 2,771,281,119.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,928,345,147.21 | 2,501,416,112.91 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,473,374,032.00 | 1,881,797,968.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,073,449,950.08 | 1,297,742,663.65 |
| 210102 | Нэмэгдэл | 293,736,078.92 | 476,432,874.00 |
| 210104 | Урамшуулал | 106,188,003.00 | 107,622,431.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 191,873,770.12 | 235,133,080.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 133,988,367.71 | 160,933,384.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,672,086.28 | 18,950,099.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,670,528.85 | 14,992,359.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,875,656.48 | 3,659,069.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,667,130.80 | 36,598,166.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,829,467.71 | 66,232,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,601,174.99 | 15,831,456.52 |
| 210302 | Түлш, халаалт | 35,981,019.72 | 39,914,563.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,247,273.00 | 10,486,080.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 61,386,628.32 | 33,595,467.93 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,453,000.00 | |

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 400,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,445,306.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 46,415,472.32 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 545,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,127,850.00 | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 33,595,467.93 |
| 2105 | Нормативт зардал | 990,073.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 990,073.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 13,387,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 13,387,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,048,750.00 | 28,778,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,048,750.00 | 7,993,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 20,784,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,842,426.06 | 242,492,196.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 79,532,233.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,991,533.00 | 30,430,401.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 125,350,893.06 | 132,529,562.05 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,799,582.17 | 269,865,006.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 118,505,471.00 | 269,864,860.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,698,073.00 | 229,335,960.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,866,276.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,969,122.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,972,000.00 | 40,528,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,294,111.17 | 146.35 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,294,111.17 | 146.35 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 132,277,423.64 | 5,200,794,329.42 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,038,318.00 | |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (1,038,318.00) | |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 131,239,105.64 | 5,200,794,329.42 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,948,752,204.00</u> | <u>2,841,760,650.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 70,435,150.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 70,435,150.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 70,435,150.00 |

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 7,880,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 62,554,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,948,752,204.00 | 2,771,325,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 2,627,281,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 2,627,281,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,762,179,400.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 130,880,004.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 92,323,004.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 38,557,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 55,692,800.00 | 144,043,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,692,800.00 | 144,043,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,948,752,204.00 | 2,622,286,089.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,948,752,204.00 | 2,622,286,089.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,823,952,621.83 | 2,352,421,082.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,471,698,661.88 | 1,881,797,968.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,073,449,950.08 | 1,297,742,663.65 |
| 210102 | Нэмэгдэл | 292,060,708.80 | 476,432,874.00 |
| 210104 | Урамшуулал | 106,188,003.00 | 107,622,431.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 193,549,140.24 | 235,133,080.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 135,663,737.83 | 160,933,384.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,672,086.28 | 18,950,099.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,670,528.85 | 14,992,359.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,875,656.48 | 3,659,069.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,667,130.80 | 36,598,166.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,829,467.71 | 66,232,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,601,174.99 | 15,831,456.52 |
| 210302 | Түлш, халаалт | 35,981,019.72 | 39,914,563.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,247,273.00 | 10,486,080.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,176,896.00 | 4,005,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,453,000.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 400,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,445,306.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 11,207,690.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,211,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,459,900.00 | 4,005,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,650,973.00 | |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,063,573.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 587,400.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 43,455,500.00 | 13,681,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,455,500.00 | |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 13,681,300.00 |

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,350,950.00 | 28,778,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,350,950.00 | 7,993,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 20,784,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,241,033.00 | 122,793,434.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 91,624,903.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,741,033.00 | 31,168,531.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,799,582.17 | 269,865,006.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 118,505,471.00 | 269,864,860.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,698,073.00 | 229,335,960.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,866,276.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,969,122.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,972,000.00 | 40,528,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,294,111.17 | 146.35 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,294,111.17 | 146.35 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 219,474,560.72 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 104,506,010.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 104,506,010.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 104,506,010.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 104,506,010.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | (104,506,010.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 114,968,550.72 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 114,968,550.72 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|---------------------------|---|
| 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,441,984,414.04 | 2,175,820,405.69 | (3,617,804,819.73) | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,441,984,414.04 | 2,175,820,405.69 | (3,617,804,819.73) | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 5,200,794,329.42 | 5,200,794,329.42 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,441,984,414.04 | 2,175,820,405.69 | 1,582,989,509.69 | 5,200,794,329.42 |

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,841,760,700.00 | 2,726,791,952.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,841,760,700.00 | 2,726,791,952.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,553,787,753.65 | 2,456,927,092.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,960,504,653.65 | 1,881,797,968.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,433,329,532.65 | 1,297,742,663.65 |
| 210102 | Нэмэгдэл | 461,719,297.00 | 476,432,874.00 |
| 210104 | Урамшуулал | 65,455,824.00 | 107,622,431.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 245,121,100.00 | 235,133,080.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 166,695,100.00 | 160,933,384.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,606,300.00 | 18,950,099.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,685,300.00 | 14,992,359.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,921,400.00 | 3,659,069.72 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,213,000.00 | 36,598,166.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,232,101.00 | 66,232,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,831,457.52 | 15,831,456.52 |
| 210302 | Түлш, халаалт | 39,914,564.48 | 39,914,563.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,486,081.00 | 10,486,080.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,005,200.00 | 4,005,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,005,200.00 | 4,005,200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,928,346.35 | 15,928,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,246,900.00 | 2,246,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,681,447.35 | 13,681,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,778,000.00 | 28,778,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,993,900.00 | 7,993,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,784,100.00 | 20,784,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 233,218,500.00 | 225,052,544.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 202,042,400.00 | 193,884,013.00 |

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 31,176,100.00 | 31,168,531.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 287,972,800.00 | 269,864,860.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 287,972,800.00 | 269,864,860.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 247,443,900.00 | 229,335,960.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,528,900.00 | 40,528,900.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,841,760,700.00 | 2,841,760,503.65 |
| 12 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 70,435,200.00 | 70,435,150.00 |
| 120041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,880,400.00 | 7,880,400.00 |
| 120042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 62,554,800.00 | 62,554,750.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,627,281,700.00 | 2,627,281,700.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,627,281,700.00 | 2,627,281,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 144,043,800.00 | 144,043,653.65 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 144,043,800.00 | 144,043,653.65 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 114,968,550.72 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,380.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 5,380.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Тус сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 5,380,000.00 /таван сая гурван зуун наян мянга/ төгрөгийн 2 ширхэг таблет биетээр байхгүй байгаа нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн албан шаардлага: Хөрөнгийг биетээр хүлээн авч акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриаар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ай Ти Зон ХХК -аас нэг бүр нь 2,690.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг таблет худалдан авсан боловч бараа биетээр ирээгүй байна. | 1 | 5,380.0 | | | 1 | 5,380.0 | | |
| Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 3 | 5,380.0 | | | 1 | 5,380.0 | 2 | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 8 мэдээллийг мэдээлээгүй байна. | 1 | 87,667.3 | | | | | 1 | 87,667.3 |
| Дүн | 1 | 87,667.3 | | | | | 1 | 87,667.3 |



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 98/01 ДОО-2023/131/НА-СТА-ТШЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 5,380,000.00 /таван сая гурван зуун наян мянга/ төгрөгийн 2 ширхэг таблет бодитоор байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.3 "өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх 5,380,000.00 төгрөгийн үнэ бүхий 2 хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас хүлээн авч, тооцоо хийж дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн захирал М.Наранжаргал, нягтлан бодогч Б.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.АРИУНАА

011040413